

**МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙ НИЙГЭМЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР НИЙГМИЙН БОДЛОГО,  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНООС  
ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 10 дугаар  
сарын 07-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн А.Бакей**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Р.Амаржаргал, Д.Батцогт нарын 16 гишүүн 2015 оны 08 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэх эсэх тухай асуудлыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Уг хуулийн төсөлд МУЗН-ийн статусыг шинэчилж, төрд хүмүүнлэгийн салбарт нэмэлт хүч болж, туслах үүрэг хүлээж ажилладаг, үндэсний хэмжээний хүмүүнлэгийн байгууллага мөн болохыг тодорхойлж, олон улсын хэмжээнд хэрэглэгддэг хүмүүнлэгийн үйл ажиллагааны таних тэмдгийг хэрэглэх, хамгаалах зэрэг асуудлыг тусгасан байна.

Хуулийн төслийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн А.Бакей үйл ажиллагааны үндсэн зарчмаа тодорхой болгох, Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл, Е.Отгонбаяр, Д.Сарангэрэл нар олон мянган гишүүд, дэмжигчтэй тус нийгэмлэгийн үйл ажиллагаанд улсын болон орон нутгийн төсвөөс тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлж, төрийн зарим үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлж, хамтран ажиллах нь зүйтэй гэсэн саналыг хэлэв.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар тус Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**

**Д.БАТЦОГТ**

